

“Үндэсний Эрүүл Мэндийн Удирдлагын мэдээллийн системийг сайжруулах байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх нь” төсөл

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	“Үндэсний Эрүүл Мэндийн Удирдлагын мэдээллийн системийг сайжруулах байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх нь” төсөл 2016 оны 4 сарын 1- ний өдрөөс эхэлсэн.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	ДЭМБ /буцалтгүй тусламж
3.	Хэрэгжүүлэгч байгууллага	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: КОЙКА ОУБ
	Хэрэгжих нийт хугацаа	Захиалагч байгууллага: ЭМХТ
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1.: H-info програмыг сайжруулах анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулах, статистикийн чанарыг сайжруулах
5.	Нийт төсөв	2016 онд 61,220,000 төгрөг
6.	Хийгдсэн ажил	<p>M-Health: Энэ модулийг гэрийн эргэлтийн тусламж үйлчилгээг дэмжих ухаалаг гар утас болон таблет, суурин компьютер, зөөврийн төхөөрөмжүүдэд суулган хэрэглэх хувь хүний эрүүл мэндийн мэдээлэл болон бүртгэх системийг загварчлал хийх</p> <p>“Эрүүл мэндийн анхан шатны болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь” төслийн хүрээний Сонгино хайрхан дүүргийн 2 хороо, Өмнөговь аймгийн 3 суманд төслийн баг програм боловсруулсан. Уг төслөөр түгээсэн 10 таблет төхөөрөмжөөр Халдварт, халдварт бус өвчний эрт илрүүлгийн асуумжаар 8000 хүний халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн мэдээний сан үүсгэсэн байна. Хийгдсэн програмаас гарах үр дүнд мэдээний санг excel програмруу хөрвүүлэн ашиглах, мэдээний санг харах боломжтой. Програм нь online болон offline хэлбэрээр цуглуулдаг, гар утас болон ухаалаг төхөөрөмж ашиглан мэдээлэл цуглуулах боломжтойгоороо давуу талтай болсон. Уг програмд халдварт бус өвчний 7, халдварт өвчний 5, хүн ам зүйн мэдээ, ерөнхий биеийн үзлэг гээд нийт 14 асуумж мэдээлэл оруулсан. Энэхүү систем нь иргэнд суурилсан мэдээний сан үүсгэнэ. Зөөврийн зүрхний эхо аппараттай энэ систем холбогддог, зүрхний эхо зургийг дамжуулдаг давуу талтай байна.</p> <p>Мөн ЦЭМБ–ийн ажиллах зарчим болон харагдах байдлыг загварчилсан.</p> <p>Алслагдсан хүн амын дунд тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчний мэдээг цуглуулах, гэрийн эргэлтийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох эхлэл тавигдсан байна.</p>